

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/61/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.8.1.1	Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15
5	Хавсралт	19
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/537
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол шуудан ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол шуудан ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, хувь хүний орлогын албан татварын тайлан, анхан шатны баримтжуулалттай холбоотой 7 зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол шуудан ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, аудитын менежер Г.Мөнхбаяр, аудитор Г.Отгонбаатар, аудиторовн туслах А.Хонгорзул, Б.Данзандорж, Ч.Алтангэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Мэжик консалтинг аудит ХХК-д 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 01/238 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС,НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

Монгол шуудан ХК нь “Дэлхийн дэвшилтэт технологид хүрсэн, чанартай, цогц үйлчилгээгээр хүн бүрийн шуудангийн хэрэгцээг төгс хангах” гэсэн үйл ажиллагааны чиглэл зорилтыг тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор үүсгэн байгуулагдсан байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 2016/05 тоот тогтоолоор Монгол шуудан ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг доорх байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Захидал, бичиг, боодол, илгээлт зэрэг шуудангийн бүх нийтийн үйлчилгээ;
- Захиалгат илгээмжийн худалдаа;
- Хадгаламж, даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цалин хөлс олгох, мөнгөн гуйвуулга хийх зэрэг санхүүгийн үйлчилгээ;
- Шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, хэвлүүлэх, борлуулах;
- Гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах;
- Монгол Улсын Шуудангийн тухай хуулиар зохицуулсан бусад үйлчилгээ

Монгол шуудан ХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол шуудан ХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Харилцааны холбооны тухай хууль
- Шуудангийн тухай хууль

Тайлан хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол шуудан ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол шуудан ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол шуудан ХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Веритеч” програм хангамж ашигладаг байна.

Монгол шуудан ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол шуудан ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрт хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардалыг сонгов.

Монгол шуудан ХК-ийн 2018 оны орлого дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 14,223.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 142.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын түвшингийн суурь үзүүлэлтийг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	116.7	
2	Албан шаардлага өгсөн	1	0.8	
	Дүн	8	117.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг 0.8 сая төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 17/27 дүгээр тогтоолоор Монгол шуудан ХК-ийн 2018 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Орлогын гүйцэтгэл:

2018 онд 15,473.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 1,083.9 сая төгрөгөөр буюу 8 хувиар давуулан биелүүлсэн байна. Мөн гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар буюу 1,805.7 сая төгрөгөөр өссөн байна.

Монгол шуудан ХК нь 2018 онд транзит шуудангийн орлогыг 1,600.0 сая төгрөгөөр төсөвлөсөн ба гүйцэтгэлээр 3,480.1 сая төгрөг болж төсөвлөсөн дүнгээс 1,880.1 сая төгрөгөөр буюу 118 хувиар өссөн нь орлогын өсөлтөнд нөлөөлсөн байна.

Зардлын гүйцэтгэл:

2018 онд 14,223.7 сая төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулж зардлын төлөвлөгөөг 513.7 сая төгрөг буюу 4 хувиар хэтрүүлсэн байна. Мөн гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18 хувиар буюу 2,203.3 сая төгрөгөөр өссөн байна.

Зардлын өсөлтөнд нөлөөлсөн гол үзүүлэлт нь транзит шуудангийн орлогын өсөлттэй холбоотойгоор тээврийн зардал 478.1 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага, өглөг: Өмнөх оны мөн үеэс богино хугацаатай авлага 2,284.6 сая төгрөгөөр өссөн, богино хугацаат өр төлбөр 7,936.8 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн бууралт нь 2017 онд байгуулагдсан транзит шуудангийн туршилтын гэрээний дагуу 2017 оны 2,3-р улирлын транзит шуудан тээврийн төлбөр байгууллагын дансанд орсон ба үүнээс Оросын холбооны улсын шууданд төлөх төлбөр 2017 онд багтаж төлөгдөөгүйгээс шалтгаалсан байна. 2018 онд транзийн шуудангийн үйлчилгээтэй холбоотойгоор 53,504.8 сая төгрөгийг хүлээн авч 60,813.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Эдгээр дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны бусад мөнгөн орлого, бусад мөнгөн зарлагын хэсэгт харуулсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол шуудан ХК-ийн нийт хувьцааны 65,727,000 ширхэг буюу 66 хувийг төрийн өмч, 28,218,435 ширхэг буюу 28.34 хувийг Ард санхүүгийн нэгтгэл ХК, 1,903,443 ширхэг буюу 1.91 хувийг Ард даатгал ХХК, 3,736,315 ширхэг буюу 3.75 хувийг бусад 794 хувьцаа эзэмшигч тус тус эзэмшиж байна.

Ногдол ашгийн мэдээлэл:

Монгол шуудан ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 18/04 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 3,68 төгрөг буюу 2017 оны нийт цэвэр ашгийн 30 хувь болох 367.3 сая төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараасан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол шуудан ХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Монгол шуудан ХК нь 2018 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 19 мэдээлэл, нийт 20 мэдээллүүдийг оруулсан ба хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 2018 оны 2, 10 дугаар саруудад хугацааа хоцорч байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчлийг арилгах 9 зөвлөмж өгөгдсөнөөс 7 зөвлөмжийг 100 хувь биелүүлж, 2 зөвлөмжийг 90 хувьтай тус тус биелүүлж нийт дүнгээр 98 хувьтай биелүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол шуудан ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол шуудан ХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Монгол шуудан ХК-ийн касс, харилцах дансны ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад анхан шатны баримтууд нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалд нийцэхгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг дагаж мөрдөөгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шинээр батлагдсан анхан шатны маягтын шинэчлэлийг тухай бүр нь програмд бүрэн оруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Анхан шатны баримтын шинэчлэлийг програмдаа оруулж, тохируулга хийлгэж ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

Монгол шуудан ХК-ийн 9 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол нь 2.4 сая төгрөгөөр илүү тооцоологдсон байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалын 2.2 дугаар зүйлийн 5.3-т “элэгдүүлэх хугацаа гэдэг нь аж ахуйн нэгж үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс түүнийг данснаас хасах хүртэлх хугацаанд тооцох ба элэгдүүлэх хугацааг тухайн аж ахуйн нэгж ашиглахаар төлөвлөж буй хугацаа, үйлдвэрлэх бүтээгдэхүүн, гүйцэтгэх ажил үйлчилгээний тоо хэмжээ, удирдлагын гаргасан шийдвэр, үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаа зэрэгт үндэслэн тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв тооцоолж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санхүүгийн програмд тохируулга хийж алдаатай тооцоолыг залруулна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.3.1 Илрүүлэлт:

1. Анхан шатны баримт бүрдэл дутуу 43.3 сая төгрөгийн бараа материалын орлогын ажил гүйлгээ бүртгэлд тусгагдсан байна.

2. Анхан шатны баримт бүрдэл дутуу болон алдаатай касс болон харилцахын зарлагын 37.3 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг сайтар хангаж ажиллах, шат дараалсан хяналтыг сайжруулах, дотоод хяналтыг үр дүнтэйгээр гүйцэтгэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Анхан шатны баримтын иж бүрдлийг хангахад цаашид анхаарч ажиллана.

3.4 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.4.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд жирэмсэн болон хүүхдээ асарч буй эхчүүдийн кодны сонголтыг зөрүүлж тусгаснаас болж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 9 хувиар хийх ёстой тооцооллыг 12 хувиар тооцоолж тайлагнасан байна.

Энэ нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 211/A112 тоот “Сангийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал”-ын “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрөл, код ” гэсэн хавсралтад; “Хүүхэд асрах, чөлөөтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан эх” 8 хувь, “Жирэмсний, амаржсаны амралттай байгаа ажилтан эх” 11-13 хувь байна гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тайланг хууль, журмын дагуу бэлтгэж тайлагнаж байх, цалингийн тооцоололд хийж буй дотоод хяналтыг сайжруулах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.5.1 Илрүүлэлт:

Кассын зарлагын гүйлгээг 90-ээс дээш хоногийн дараа үүсгэсэн 36 ажил гүйлгээ байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5.санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн.

3.5.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Кассын зарлагын гүйлгээг нөхөж бүртгэх, засах эрхийг програм хангамжид хязгаарлах, засвар хийх эрхийг ахлах нягтлан бодогч нарт шилжүүлэх

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллана.

3.6 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.6.1 Илрүүлэлт:

1. Үнэт цаас бэлтгэн нийлүүлэх төвийн ажилтан Ж.Ганхуягийн хувь хүний орлогын албан татварын тооцооллыг хийхдээ 2.7 сая төгрөгөөр илүү тооцоолон суутгаж, төлсөн байна.

2. 2018 оны 4 дүгээр сараас 12 сарын хооронд нийгмийн даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдасны тэтгэмж, жирэмсэн болон амаржсны тэтгэмжээс 9.1 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тайлагнасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, 16.1.10-д “хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого” -ыг чөлөөлнө гэж тус тус заасныг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тайланг хуулийн дагуу бэлтгэж, цалингийн тооцоолол хийж буй ажилтнуудад тавих дотоод хяналтыг сайжруулах

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 оны хувь хүний орлогын албан татварын тайланг засч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.7 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.7.1 Илрүүлэлт:

Идеал групп ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 21.8 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал нь 2009 оны үед бүртгэлд тусгагдсан байна. Зураг төслийн ажил дуусч хүлээн авсан боловч барилгын ажил хийгдээгүй тул урьдчилж төлсөн зардал бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх журам” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.7.2 Эрсдэл:

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл илүү илэрхийлэгдсэн байх

3.7.3 Өгсөн зөвлөмж:

Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэлд жил бүрийн эцэст үнэлгээ хийж, үлдэгдлийн зөрүүтэй насжилт ихтэй үлдэгдлийг холбогдох удирдлагаас зөвшөөрөл авч тайланг бодитой байдлаар бэлтгэх

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Энэхүү төлбөр тооцоотой асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэд хэдэн удаа хэлэлцүүлсэн байгаа, уг асуудлыг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэнэ

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,659,316,320.01	17,267,083,063.60
Дансны авлага	2,791,724,588.39	5,788,142,997.08
Татвар, НДШ – ийн авлага	316,093.06	11,214,579.94
Бусад авлага	741,438,699.23	368,786,936.46
Бусад санхүүгийн хөрөнгө	350,000,000.00	-
Бараа материал	1,723,046,229.79	2,095,115,996.76
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	89,788,837.99	106,902,720.24
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	32,355,630,768.48	25,637,246,294.08
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,165,804,273.31	8,068,309,950.53
Биет бус хөрөнгө	330,310,766.78	304,812,810.22
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,496,615,040.09	8,373,622,760.75
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	40,852,245,808.57	34,010,869,054.83
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	18,315,301,608.08	10,213,019,917.75
Цалингийн өглөг	442,279.64	0.29
Татварын өр	116,473,223.76	69,130,787.96
НДШ - ийн өглөг	10,546,707.79	0.00
Урьдчилж орсон орлого	848,689,798.32	989,525,152.12
Бусад богино хугацаат өр төлбөр	143,725,802.28	226,701,941.52
Богино хугацаат өр төлбөрийн дүн	19,435,179,419.86	11,498,377,799.63
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Нийт өр төлбөрийн дүн	19,435,179,419.86	11,498,377,799.63
Эздийн өмч		
Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
- хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
- хувьцаат	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.00	2,538,512,210.45
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	2,710,106,959.73	2,710,106,959.73
Хуримтлагдсан ашиг	2,829,891,394.68	3,925,316,261.18
Эздийн өмчийн дүн	21,417,066,388.71	22,512,491,255.21
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	40,852,245,808.57	34,010,869,054.84

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (Цэвэр)	12,116,604,477.20	14,386,649,985.51
Борлуулалтын өртөг	11,150,358,677.41	13,144,919,741.79
Нийт ашиг (алдагдал)	966,245,799.79	1,241,730,243.72
Түрээсийн орлого	101,000,000.00	107,973,100.29
Хүүний орлого	1,450,619,977.71	978,515,051.27
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	822,000.00
Борлуулалт маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	700,682,373.39	885,838,643.78
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	169,359,316.00	193,018,362.95
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(299,328,330.11)	490,648,872.41
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,093,385.43	1,588,718.55
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,351,589,143.15	1,742,420,979.51
Орлогын татварын зардал	127,432,364.97	182,153,356.46
Татварын дараах ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Бусад олз гарз	-	-
Орлогын нийт дүн	-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	1,224,156,778.18	1,560,267,623.05

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	51,837,355,502.17	73,491,611,313.80
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,319,362,827.26	10,722,574,208.53
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	78,217,316.45	26,889,263.00
Татаас, санхүүжилтийн орлого	3,168,063,448.94	2,949,578,177.70
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	37,271,711,909.52	59,792,569,664.57
Мөнгөн зарлагын дүн (-)	38,766,556,000.67	84,212,951,149.00
Ажиллагчдад төлсөн	5,311,806,780.42	5,831,386,746.04
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,236,350,390.68	1,565,126,881.78
Бараа материал худалдан авахад төлсөн	1,337,472,506.90	1,840,637,770.90
Ашиглалтын зардалд төлсөн	1,696,531,086.10	1,521,112,339.01
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	733,484,374.92	2,057,024,179.61
Татварын байгууллагад төлсөн	1,000,226,694.72	1,074,823,569.66
Даатгалын төлбөрт төлсөн	39,380,686.45	47,385,763.25
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	27,411,303,480.48	70,275,453,898.75
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,070,799,501.50	(10,721,339,835.20)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,266,090,374.95	1,544,805,269.79
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,850,000.00	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	666,800.00	-
Хүлээн авсан хүүний орлого	1,160,573,574.95	1,194,805,269.79
ХО бусад мөнгөн орлого	6,100,000,000.00	350,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,247,082,107.88	531,676,476.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	805,383,107.88	523,176,476.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	91,699,000.00	8,500,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
ХО бусад мөнгөн зарлага	350,000,000.00	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,019,008,267.07	1,013,128,793.79
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
СҮА-ны бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	303,855,696.56	442,596,781.13
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Төлсөн ногдол ашиг	291,705,696.56	354,457,491.53
СҮА-ны бусад мөнгөн зарлага	12,150,000.00	88,139,289.60
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(303,855,696.56)	(442,596,781.13)
валютын ханшийн зөрүү	(808,046,705.03)	758,574,566.13
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	17,977,905,366.98	(9,392,233,256.41)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,681,410,953.03	26,659,316,320.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,659,316,320.01	17,267,083,063.60

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	1,907,710,986.50	20,494,885,980.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл						
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,224,156,778.18	1,224,156,778.18
5	Бусад дэлгэрэнгүй орлого						
6	Өмчид гаргасан өөрчлөлт						
7	Зарласан ногдол ашиг					(301,976,370.00)	(301,976,370.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	2,829,891,394.68	21,417,066,388.71
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(97,932,543.74)	(97,932,543.74)
11	Залруулсан үлдэгдэл						
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,560,267,623.05	1,560,267,623.05
13	Бусад дэлгэрэнгүй орлого						
14	Өмчид гарсан өөрчлөлт						
15	Зарласан ногдол ашиг					(366,910,212.81)	(366,910,212.81)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	9,958,636,300.00	2,538,512,210.00	3,379,919,523.85	2,710,106,960.18	3,925,316,261.18	22,512,491,255.21

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо: 2019/03/15	Аудитын нэр: Монгол шуудан ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2019/61/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол шуудан ХК	сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн тооцооллыг 0.8 сая төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан байна.	0.8	Албан шаардлага			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
2	Монгол шуудан ХК-ийн касс, харилцах дансны ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад анхан шатны баримтууд нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалд нийцэхгүй байна.	-	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
3	Монгол шуудан ХК-ийн 9 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол нь 2.4 сая төгрөгөөр илүү тооцоологдсон байна.	2.4	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
4	Анхан шатны баримт бүрдэл дутуу 43.3 сая төгрөгийн бараа материалын орлогын ажил гүйлгээ бүртгэлд тусгагдсан байна. Анхан шатны баримт бүрдэл дутуу болон алдаатай касс болон харилцахын зарлагын 37.3 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгагдсан байна.	80.6	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
5	Нийгмийн даатгалын тайланд жирэмсэн болон хүүхдээ асарч буй эхчүүдийн кодны сонголтыг зөрүүлж	-	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг

	тусгаснаас болж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 9 хувиар хийх ёстой тооцооллыг 12 хувиар тооцоолж тайлагнасан байна.						
6	Кассын зарлагын гүйлгээг 90-ээс дээш хоногийн дараа үүсгэсэн 36 ажил гүйлгээ байна.	-	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
7	Үнэт цаас бэлтгэн нийлүүлэх төвийн ажилтан Ж.Ганхуяг /РД: ШБ87051870/-ийн хувь хүний орлогын албан татварын тооцооллыг хийхдээ 2.7 сая төгрөгөөр илүү тооцоолон суутгаж, төлсөн байна. 2018 оны 4 дүгээр сараас 12 сарын хооронд нийгмийн даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдасны тэтгэмж, жирэмсэн болон амаржсны тэтгэмжээс 9.1 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тайлагнасан байна.	11.8	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
8	Идеал групп ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 21.8 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал нь 2009 оны үед бүртгэлд тусгагдсан байна. Зураг төслийн ажил дуусч хүлээн авсан боловч барилгын ажил хийгдээгүй тул урьдчилж төлсөн зардал бүртгэлтэй байна.	21.8	Зөвлөмж			Гүйцэтгэх захирал Ерөнхий Нягтлан бодогч	Б.Анхбаатар Б.Наранцэцэг
Нийт		117.5					

